



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас/Факс: (976-11) 32-71-99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2022. 07. 01 № 03/3489
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар батлагдсан 9 бүлэг сэдвийн 38 хотын стандартыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдүүлж эхлэхтэй холбогдуулан дараах чиглэлийг хүргүүлж байна.

-Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/851 дүгээр захирамжаар батлагдсан “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө”-тэй танилцаж, хариуцсан арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулж ажлын үр дүнгээ 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тайлагнах;

-2023 оноос эхлэн хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний зураг төсөл, 2023 оны төсвийн саналаа боловсруулахдаа батлагдсан хотын стандартын хэм хэмжээг мөрдүүлэх нөхцөлийг хангахуйц төсвийн тооцоолол хийх

Нийслэлийн Засаг даргын А/851 дүгээр захирамж, “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө”-г хавсралтаар хүргүүлэв.

ДАРГА



Т.ОЮУНЧИМЭГ

ЧИГЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ АЛБАН БИЧИГ ХҮРГҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГУУД

1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
2. Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар
3. Нийслэлийн Байгаль орчны газар
4. Нийслэлийн Боловсролын газар
5. Нийслэлийн Аялал жуулчлалын газар
6. Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар
7. Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын газар
8. Нийслэлийн Биеийн тамир, спортын газар
9. Нийслэлийн Замын хөгжлийн газар
10. Нийслэлийн Соёл урлагийн газар
11. Нийслэлийн Сургалт судалгаа, олон нийттэй харилцах газар
12. Нийслэлийн Нийтийн тээврийн газар
13. Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
14. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
15. Нийслэлийн Эрүүл мэндийн газар
16. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
17. Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газар
18. Нийслэлийн Орон сууцны бодлогын газар
19. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
20. Баянгол дүүргийн Засаг дарга Ө.Сумъяабаатар
21. Баянзүрх дүүргийн Засаг дарга Н.Баярмөнх
22. Чингэлтэй дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэл
23. Сүхбаатар дүүргийн Засаг дарга Х.Болормаа
24. Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга Н.Алтаншагай
25. Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан
26. Налайх дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазар
27. Багахангай дүүргийн Засаг дарга С.Эрдэнэбаяр
28. Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн
29. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ
30. Улаанбаатар зам засвар арчлалт ОНӨААТҮГ
31. Геодези, усны барилга байгууламж ОНӨААТҮГ
32. Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ
33. Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ
34. Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ
35. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж
36. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 8/851

Улаанбаатар хот

Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл
арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26 дугаар тогтоол, "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, холбогдох нутгийн захиргааны байгууллагуудыг мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллахыг Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т даалгасугай.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг дүрмээр хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлт, явц, үр дүнг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад үүрэг болгосугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хариуцсан чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө нарт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

111020004154

ХОТЫН СТАНДАРТЫГ МӨРДҮҮЛЭХ БЭЛТГЭЛ ХАНГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ



Нийслэлийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 13-ны өдрийн
11851/2022 захиралын
хавсралт

№	Хотын стандартын нэр		Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоон үзүүлэлт		Төсөв /Мян.төг/	Хугацаа		Хямаарах байгууллага		Тайлагнах ХУГАЦАА
	Бүлгийн нэр	Стандартын тоо		Хэмжих нэгж	Тоо		Эхлэх	Дуусах	Хариуцах	Хамтрах	
1	Хот төлөвлөлт, хот байгуулалт	1	Барилга угсралт, зураг төсөл зохионч байгууллагуудад хотын стандартын талаар сурталчлан таниулах сургалт, уулзалтыг зохион байгуулах	Оролцогч байгууллагын тоо	300	-	2022.06.01	2022.07.23	ХБХГ	ХСХГ, НМХГ, НОБГ	2022.08.15
2	Ногоон байгууламж	5	2023 онд хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээнд хотын стандартыг мөрдүүлэхтэй холбоотой хангах, төсөв тооцоог шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах	Оролцогч байгууллагын тоо	48	-	2022.06.01	2022.06.20	УБЗАА	ХСХГ	2022.06.30
				арга хэмжээний тоо	1	-	2022.06.25	2022.09.10	УБЗАА	Хот тохижилтын газар	2022.09.25

3	"Иж Бүрэн Гудамж"	3	Явган хүний зам, дугуйн замд тавигдах хотын стандартын талаар зураг төсөл боловсруулагч, захиалагчийн хяналт тавих байгууллагууд, тэдгээрийн ИТА нар т сургалт, зөвлөмж өгөх	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	100	-	2022.06.01	2022.08.01	ХБХГ	НХОГ ХСХГ	2022.09.25
			2023 онд хэрэгжих хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын даалгавар, архитектур төлөвлөлтийн даалгаварт хотын стандартын туслуулах, зураг төслийг баталгаажуулах	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	100	-	2022.06.01	2022.08.01	ХБХГ	НХОГ ХСХГ	2022.09.25
4	Нийгмийн дэд бүтэц	4	Сургууль, цэцэрлэгийн гадна орчны аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Төрийн байгууллагын ТОО	281 сургууль, 674 цэцэрлэг	-	2022.06.02	2022.08.01	НБГ	УБЗАА, ХСХГ	2022.09.10
			Сургууль, цэцэрлэгийн гадна орчны аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Төрийн байгууллагын ТОО	90	-	2022.06.01	2022.09.01	УБЗАА	Нутгийн захиргааны байгууллагууд, дүүргүүд	
5	Худалдаа, үйлчилгээний газрын гадна орчин	3	Худалдаа, үйлчилгээний газрын гадна орчны талаар хотын стандартын сургалт хийх, мэдээллээр хангах	Сургалтад хамрагдсан иргэн, аж ахуйн байгууллагын ТОО	600	-	2022.06.02	2022.08.31	УБЗАА	ХСХГ, 9 дүүргийн ЗДТГ-ын ХХУХ	2022.09.10

	<p>Худалдаа, үйлчилгээний жишиг гудамж байгуулах. Гадна хаягийн стандартын хэрэгжилтийг хангуулах</p>	ААН-ын тоо	20	-	2022.06.02	2022.08.31			2022.09.10
	<p>Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний байгууллагын гадна орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийн судалгааг хийх</p>	ААН-ын тоо	100	-	2022.06.02	2022.08.31			2022.09.10
	<p>Мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай уулзалт зохион байгуулах</p>	оролцогч байгууллагын тоо	8	-	2022.06.02	2022.06.30			2022.06.30
	<p>Зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулах</p>	ААН-ийн тоо	650	-	2022.06.01	2022.07.01			2022.07.25
	<p>Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-уудын түвшинд стандартыг мөрдүүлэх арга хэмжээг авах</p>	ААН-ийн тоо		-	2022.06.01	2022.09.01	НАЖТ	ХСХГ, НБОГ	2022.09.10

6	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	10	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн бүртгэл, тоон судалгааг шинэчлэх,	хэрэгжилт, хувь	100	-	2022.06.02	2022.08.30	УБЗАА	ХСХГ, ХТГ, дүрлүүдийн ЗДТГ	2022.09.10
			Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн ашиглалт засвар үйлчилгээг харуулагч байгууллагуудыг мэдээлэл, арга зүйгээр хангах	байгууллагын тоо	10	-	2022.06.02	2022.08.30	УБЗАА	ХСХГ, ХТГ, дүрлүүдийн ЗДТГ	2022.09.10
7	Зорчигч тээврийн үйлчилгээ	5	Хотын стандартын мөрдүүлэх хүрээнд засаж сайжруулах нийтийн тээврийн хэрэгслийн тоо хэмжээг тодорхойлох	Судалгаанд хамрагдах автобусны тоо	1243	-	2022.06.02	2022.08.30	НТГ	ХСХГ	2022.09.10
			Нийтийн тээврийн автобусны парк шинэчлэл хийх төлөвлөгөөнд хотын стандартын шаардлагуудыг тусгах	автобусны тоо	299	-	2022.06.25	2022.07.25	НТГ	ХСХГ	2022.07.25
8	Хог хаягдлын менежмент	5	Хог хаягдалтай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад таниулан сурталчлах	оролцогч байгууллагын тоо	20	-	2022.08.01	2022.09.01	УБЗАА	ХСХГ, НБОГ	2022.09.09
			ННЗБ-уудад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бууруулах үйл ажиллагааг идэвхжүүлэхэд батлагдсан хотын стандартыг хүргүүлэх, танилцуулах	оролцогч байгууллагын тоо	98	-		2022.09.01	УБЗАА	ХСХГ, НБОГ	2022.09.09

9	Гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл	2	Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн нөхцөл байдлыг судлах, стандартын хэм хэмжээг хэрхэн мөрдүүлэхтэй холбоотой суурь судалгаа хийх	Судалгааны тоо	1	-	2022.06.01	2022.08.01	УБЗАА	ХСХГ	2022.08.30
			Дээрх судалгааны үр дүнд үндэслэн батлагдсан хотын стандартыг мөрдүүлэхтэй холбоотой арга хэмжээний санал боловсруулна	Арга хэмжээний санал	1	-	2022.06.02	2022.08.01	УБЗАА	ХСХГ	2022.08.30

Батлагдсан бүх хотын стандартын нийтлэг хүрээнд зохион байгуулах арга хэмжээ

1	Хотын стандартуудыг иргэд, олон нийтэд таниулан сурталчилах	Телевизийн нэвтрүүлэг	Хэвлэл мэдээллийн байгууллага	10	-	2022.06.02	2022.09.10	НССОНХГ	ННЗБ-ууд	2022.09.10
		Видео шторк	Видео шторк тоо	22	10 000.00	2022.06.02	2022.09.10	НССОНХГ	ХСХГ	
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2016, MNS ISO 18091 стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх талаар зөвлөмж, арга зүйгээр хангах, хамтран ажиллах	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2016, MNS ISO 18091 стандартыг үйл ажиллагааг нэвтрүүлэх талаар хийж хэрэгжүүлж буй ажлын судалгаа авах	Судалгаа авах байгууллагын тоо	98	-	2022.08.20	2022.09.10	ХСХГ	ННЗБ	2022.09.10
		Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2016, MNS ISO 18091 стандартын сурталтыг нутгийн захиргааны байгууллагуудад зохион байгуулах	Сургалтанд хамруулах байгууллагын тоо	98		2022.10.10	2022.10.14	ХСХГ	ННЗБ	